

**МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТРЫН
ДЭРГЭДЭХ ДОПИНГИЙН ДАВЖ ЗААЛДАХ КОМИСС**



**ДАВЖ ЗААЛДАХ КОМИССЫН
ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ДҮРЭМ**

2023 оны 12 дугаар сарын 01-ний
өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлнэ.

Удирдах зөвлөлийн
2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 23/21 тоот
тогтоолын 2 дугаар хавсралтаар батлав.

Нэгдүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монголын Олон улсын ба Үндэсний Спортын арбитр (цаашид “Спортын арбитр” гэх)-ын дэргэдэх допингийн Давж заалдах комисс (цаашид “Давж заалдах комисс” гэх) нь Дэлхийн Допингийн эсрэг дүрэм (ДДЭД)-д нэгдсэн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 376 дугаар тогтоолоор батлагдсан “Допингийн эсрэг үндэсний дүрэм” (цаашид “ДЭҮД” гэх)-ийн 13 дугаар зүйлийн 13.8-т “Дэлхийн допингийн эсрэг дүрмийн 13.2.1 дэх заалтыг хэрэглэх боломжгүй нөхцөл байдал үүссэн үед шийдвэрийг Монголын Олон улсын ба Үндэсний Спортын арбитрын давж заалдах комисст өргөдөл гаргана. Давж заалдах үйл ажиллагааг “Үр дүнгийн удирдлагын олон улсын стандарт”-ын дагуу хийнэ” гэж заасны дагуу байгуулагдсан болно.
- 1.2. Давж заалдах комисс нь допингийн эсрэг дүрмийг зөрчсөнтэй холбоотой хэрэг, маргааныг бие даан, хараат бусаар анхан болон давж заалдах журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа (үр дүнгийн удирдлагын ажиллагаа)-г явуулж, шийдвэр гаргах зорилго бүхий Спортын арбитрын дэргэдэх байнгын үйл ажиллагаатай Комисс мөн.
- 1.3. Үр дүнгийн удирдлагын ажиллагаа (цаашид “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэх) нь эрх бүхий байгууллага, тамирчин болон бусад этгээд допингийн эсрэг дүрмийг зөрчсөн эсэх, зөрчсөн бол холбогдох шийтгэлийг оногдуулахаар явуулж буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэлнэ.
- 1.4. Давж заалдах комисс нь допингийн эсрэг дүрмийг зөрчсөн эсэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж, холбогдох шийтгэл ногдуулах эрх мэдлээ Дэлхийн допингийн эсрэг дүрэмд нэгдсэн Монгол улсын нэрийн өмнөөс хэргийг шийдвэрлэх байгууллагын хувьд харьяалан шийдвэрлэх бүрэн эрхтэй байна.
- 1.5. Давж заалдах комиссын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийг Дэлхийн допингийн эсрэг дүрэмд нэгдсэн Монгол улсын Допингийн эсрэг үндэсний дүрэмтэй уялдуулсан болно.
- 1.6. Давж заалдах комиссын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийг батлахдаа Дэлхийн допингийн эсрэг агентлагаар урьдчилан хянуулж, зөвшөөрөл авсан болно.
- 1.7. Давж заалдах комисс нь анхан болон давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг энэхүү дүрэм болон “Үр дүнгийн удирдлагын Олон улсын стандарт”-ыг баримтлан явуулна.
- 1.8. Давж заалдах комисс нь орон тооны бус дарга, зургаагаас доошгүй гишүүнээс бүрдэж, гурван гишүүний бүрэлдэхүүн (цаашид “Бүрэлдэхүүн” гэх)-ээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна.
- 1.9. Давж заалдах комисст хандаж допингийн эсрэг дүрмийн зөрчлийн маргааныг шийдвэрлүүлэх талууд төрийн эрх бүхий байгууллагууд, шүүхэд аливаа адил төстэй арга хэмжээ авах хүсэлт, нэхэмжлэл, гомдол гаргах эрхээсээ шууд татгалзсан гэж тооцогдоно. Тухайн эрхийн татгалзалд холбогдох Давж заалдах комиссын шийдвэр эцсийн бөгөөд заавал биелэгдэнэ.
- 1.10. Энэхүү дүрэм нь арбитрын ажиллагаанд хамаарахгүй, Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлэхгүй.
- 1.11. Энэхүү дүрэм нь Допингийн эсрэг үндэсний дүрмийн 13 дугаар зүйлийн 13.10.1-д заасан хэрэг хэрэг хянан шийдвэрлэх дүрэм юм.
- 1.12. Давж заалдах комисс энэхүү дүрмээр хэргийг шийдвэрлэхдээ Спортод сэргээш хэрэглэхийн олон улсын конвенц, Сэргээшийн эсрэг тунхаглал, Олимпын Харт, Дэлхийн допингийн эсрэг дүрэм, Допингийн эсрэг үндэсний дүрэм, Биеийн тамир, спортын тухай хууль, Үндэсний их баяр наадмын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, Олон улсын стандартуудыг удирдлага болгохоос гадна тэдгээрийн практик, ерөнхий шаардлагад нийцүүлнэ. Энэхүү дүрмийн оноосон нэр томъёо дараах утга, агуулгыг илэрхийлнэ.

- 1) “Сэргээшийн эсрэг тунхаглал” гэдэг нь Спортод сэргээшийн эсрэг Копенгагены тунхаглалыг хэлнэ;
- 2) “Спортод сэргээш хэрэглэхийн олон улсын конвенц” гэдэг нь Монгол улсын нэгдэн орсон конвенцийг хэлнэ;
- 3) “Олимпын Харт” гэдгийг Олон улсын олимпын хорооноос баталж 2011 оны 7 дугаар сард хүчин төгөлдөр болсон баримт бичгийг; (тухай бүр орсон нэмэлт, өөрчлөлт хамаарна)
- 4) “Дэлхийн допингийн эсрэг дүрэм” нь 2003 онд анх батлагдаж 2004 онд хүчин төгөлдөр болсон. Уг дүрэмд нийт дөрвөн удаа өөрчлөлт орсон бөгөөд 2009 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр анхны өөрчлөлт, 2015 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр хоёр дахь удаагийн өөрчлөлт, 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр гурав дахь удаагийн өөрчлөлт, 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдөр дөрөв дэх удаагийн өөрчлөлтийг тус тус оруулсан байна. 2021 оны шинэчлэгдсэн Дэлхийн Допингийн эсрэг дүрэм нь 2021 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлснийг хэлнэ; (тухай бүр орсон нэмэлт, өөрчлөлт хамаарна)
- 5) “Допингийн эсрэг үндэсний дүрэм” нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 376 дугаар тогтоолоор батлагдан хүчин төгөлдөр болсон спортод допинг хэрэглэхтэй тэмцэх ажлыг Дэлхийн допингийн эсрэг дүрмийн хүрээнд Монгол Улсад удирдах, зохион байгуулах, хянах, допинггүй спорт бий болгоход оршино. (тухай бүр орсон нэмэлт, өөрчлөлт хамаарна)
- 6) “Олон улсын стандарт” гэдэг нь Дэлхийн Допингийн эсрэг дүрмийг дэмжих зорилгоор Дэлхийн допингийн эсрэг агентлагаас баталсан стандартыг хэлнэ. Олон улсын стандартыг дагаж мөрдөх (өөр өөр стандарт, практик эсвэл процедурын эсрэг) нь олон улсын стандартад заасан журмыг зохих ёсоор гүйцэтгэсэн гэж үзнэ. Олон улсын стандартад олон улсын стандартын дагуу гаргасан техникийн баримт бичиг мөн багтана. (тухай бүр орсон нэмэлт, өөрчлөлт хамаарна)
- 7) “Биеийн тамир, спортын тухай хууль” гэж Монгол Улсын Их хурлаас 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдөр баталж 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн хуулийг хэлнэ. Энэ хуулийн зорилт нь биеийн тамир, спортын салбарын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрх зүйн үндсийг тодорхойлж, биеийн тамир, спортын салбарын харилцааг зохицуулахад оршино. (тухай бүр орсон нэмэлт, өөрчлөлт хамаарна)
- 8) “Үндэсний их баяр наадмын тухай хууль” гэж Монгол Улсын Их хурлаас 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр баталсан хуулийг хэлнэ. Энэ хуулийн зорилт нь Үндэсний их баяр наадмыг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх, Үндэсний их баяр наадмын хүрээнд үндэсний бөхийн барилдаан, сурын харваа, үндэсний хурдан морины уралдаан, шагайн харвааг зохион байгуулах, цол, чимэг олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. (тухай бүр орсон нэмэлт, өөрчлөлт хамаарна)

Хоёрдугаар зүйл. Давж заалдах комиссын харьяалал, хэлэлцээр

- 2.1. Давж заалдах комисс харьяаллын маргаан мөн эсэхийг өөрөө тогтооно. Талуудын хооронд маргааны асуудлаар, ижил асуудлаар шүүх эсвэл арбирт ажиллагаа явагдаж байгаа аливаа хууль зүйн ажиллагаанаас үл хамааран маргаан нь өөрийн харьяаллынх мөн эсэхийг шийдвэрлэнэ.

- 2.2. Давж заалдах комисс нь тамирчин эсхүл бусад этгээд допингийн эсрэг дүрмийг зөрчсөн эсэхийг шийдэж, Дэлхийн допингийн эсрэг дүрэм болон Допингийн эсрэг үндэсний дүрмийн дагуу холбогдох болон үр дагаврыг ногдлуулна.
- 2.3. Дэлхийн допингийн эсрэг дүрэм, Допингийн эсрэг үндэсний дүрэмд зааснаас бусад, эсхүл допингийн эсрэг дүрмийг зөрчсөнийг анхан шатны журмаар шийдвэрлэх бүтэц, зохион байгуулалт, бүрэлдэхүүн байхгүй, эсхүл уг маргааныг шийдвэрлэхээс татгалзсан, тогтоосон хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл санамж бичиг, гэрээ, хэлэлцээрийн заалт, эсвэл тодорхой тохиролцооны улмаас үүссэн маргааныг харьяалан шийдвэрлэнэ.
- 2.4. Давж заалдах комисс нь дээжинд дахин шинжилгээ хийхтэй холбоотой допингийн зөрчилтэй хамааралтай маргаан эсхүл Допингийн эсрэг үндэсний дүрэмд заасан хэргийг харьяалан шийдвэрлэх эрхтэй байна.
- 2.5. Гэрээний нэг хэсэг болсон хэлцлийн заалтыг гэрээний бусад нөхцөлөөс бие даасан гэж үзнэ.

Гуравдугаар зүйл. **Комиссын ажиллагаа болох газар**

- 3.1. Давж заалдах комисс болон Бүрэлдэхүүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах газар нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот байна. Энэхүү газрыг заасныг үл харгалзан, шаардлагатай тохиолдолд талуудтай зөвлөлдсөний дагуу Бүрэлдэхүүн Даргалагч бүх талтай зөвлөлдсөний дараа хуралдааныг өөр газарт явуулах шийдвэр гаргаж, тухайн хуралдаантай холбогдуулж шаардлагатай шийдвэрийг гаргаж болно.
- 3.2. Бүрэлдэхүүн гэрч, зөвлөх, шинжээч, талуудын мэдүүлгийг сонсох, баримт бичигт үзлэг, шалгалт хийх зэрэг ажиллагааг өөр газарт явуулах шийдвэр гаргаж болно.

Дөрөвдүгээр зүйл. **Комиссын хэл, бичиг**

- 4.1. Давж заалдах комиссын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хэл нь Монгол хэл байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны албан ёсны бичиг нь Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн заалт шаардлагыг хангасан байна.
- 4.2. Талууд явуулах хэл, бичгийг тохиролцож өөрөөр тогтоож болно. Хэрэв талууд энэ талаар тохиролцоогүй бол Бүрэлдэхүүн талууд аль улсын харьяат болох, тэдний сайн мэдэх хэл, бичиг зэргийг үндэслэн ажиллагааны хэл, бичгийг тогтооно.
- 4.3. Талууд эсхүл Бүрэлдэхүүн тогтоосон хэл, бичгийг хэрэг хянан шийдвэрлэх бүхий л ажиллагаанд хэрэглэнэ.
- 4.4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тогтоосон хэл, бичгээс өөр хэл, бичгээр үйлдэгдсэн аливаа бичгэн нотлох баримтыг тогтоосон хэл рүү орчуулахыг Бүрэлдэхүүн талуудаас шаардана.
- 4.5. Бичгэн орчуулга нь орчуулга хийх эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажсан, талууд эсхүл Бүрэлдэхүүн хүсвэл нотариатаар гэрчлүүлсэн байж болно.
- 4.6. Талууд монгол хэл, бичиг мэдэхгүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гадаад хэлний орчуулагч, хэлгүй, дүлий г.м. хөгжлийн бэрхшээлтэй, бичиг үсэг мэдэхгүй бол хэлмэрч оролцуулж болох бөгөөд хэлмэрчлэл болон орчуулгын үнэн зөв болон зардлыг талууд өөрсдөө хариуцна.
- 4.7. Бүрэлдэхүүн шаардлагатай тохиолдолд талуудаас үл хамаарах хөндлөнгийн орчуулагч, хэлмэрч томилж болно. Хөндлөнгийн хэлмэрч, орчуулагч тусгай тэмдэгт, дохио зангаа ашигласан бол хэрэгт авч баталгаажуулах бөгөөд зардлыг талуудаас гаргуулна.

- 4.8. Талууд өөр өөр хэлээр харилцдаг бол Бүрэлдэхүүн тэдний сайн мэдэх хэл дээр, ийм боломжгүй бол тус бүрийн орчуулагчийг оролцуулах журмаар төрөлх буюу сайн мэдэх хэл дээрээ тайлбар хийх, хуралдаанд оролцох, үг хэлэх боломжоор хангана.
- 4.9. Бүрэлдэхүүн томилогдохоос өмнө Давж заалдах комиссын дарга (цаашид “Комиссын дарга” гэх) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэлнээс өөр хэл дээр ирүүлсэн бүх баримт бичгийг ажиллагааны хэл дээрх баталгаат орчуулгын хамт ирүүлэхийг шаардаж болно. Энэхүү заалт нь Дэлхийн допингийн эсрэг агентлагт хамаарахгүй бөгөөд аливаа баримт бичгийг англи хэл дээр гаргахыг зөвшөөрөх бөгөөд тэдгээрийг монгол хэл рүү хөрвүүлж орчуулахыг шаардахгүй.

Тавдугаар зүйл. Өргөдөл гаргах, зардал

- 5.1. Допингийн эсрэг үндэсний дүрмийн дагуу Давж заалдах комисст өргөдөл гаргаж болно.
- 5.2. Давж заалдах материал бүрдүүлж байгаа тал нь шийдвэрийг нь давж заалдаж байгаа допингийн эсрэг байгууллагаас холбогдох бүх мэдээллийг авахад Спортын арбитр болон Давж заалдах комиссоос туслалцаа авах эрхтэй.
- 5.3. Өргөдлийг бичгээр Давж заалдах комиссын байнгын үйл ажиллагаа явуулж байгаа ажлын байранд биечлэн эсхүл баталгаат шуудангаар ирүүлж болно.
- 5.4. Өргөдлийг Давж заалдах комиссын нарийн бичгийн дарга хүлээн авч, тэмдэглэл үйлдэн, өргөдөл түүнд хавсаргасан материалын хуудасны тоо, огноо, цаг минутыг бүртгэнэ.
- 5.5. Өргөдөлд дараах мэдээллийг тусгаж, баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
 - 5.5.1. Хариуцагч болон аливаа гуравдагч талын (тухайлбал ажиллагааны тухай мэдэгдвэл зохих аливаа талууд) нэр, хаяг, утас;
 - 5.5.2. үйл баримт болон хууль эрх зүйн үндэслэлийн талаарх бүрэн тайлбар (тухайлбал Давж заалдах комиссоор шийдвэрлүүлэх маргааны агуулга);
 - 5.5.3. арга хэмжээ авах хүсэлт, хамааралтай тохиолдолд аливаа түр арга хэмжээ авах хүсэлт;
 - 5.5.4. хэлэлцээрийг багтаасан гэрээ эсвэл энэхүү Дүрмийн дагуу ажиллагаа явуулахаар заасан аливаа баримт бичиг;
 - 5.5.5. холбогдох допингийн эсрэг хууль, тогтоомж;
 - 5.5.6. иргэн бол иргэний үнэмлэх, хуулийн этгээд бол гэрчилгээний хуулбар;
 - 5.5.7. Давж заалдах комиссын зардал төлсөн баримт;
- 5.6. Өргөдөлд дараах мэдээллийг нэмэлтээр тусгаж болно. Үүнд:
 - 5.6.1. Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцуулах бол итгэмжлэл
 - 5.6.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах газар, хэл, бичгийн талаарх тусгайлсан хүсэлт (допингийн эсрэг дүрэм зөрчигдсөн үед Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй допингийн эсрэг үндсэн дүрмээр зохицуулагдах допингийн маргаанд холбогдох хуульд заасан хүсэлтээс бусад тохиолдолд хэргийг хянан хэлэлцэж буй Бүрэлдэхүүн тогтоогоогүй бол *lex mitior* зарчим тухайн хэргийн нөхцөл байдалд зохих ёсоор хэрэгжинэ.
- 5.7. Комиссын даргаас хэрэг үүсгэсэн тухай мэдэгдлийг талуудад хүргүүлнэ.
- 5.8. Хэрэв өргөдөл гаргагч Спортын арбитрт явагдаж буй адил шинж чанартай допингийн эсрэг ажиллагаатай холбоотой арбитрын мэдээлэл ирүүлсэн бол Бүрэлдэхүүн эсвэл хараахан томилогдоогүй бол Комиссын дарга талуудтай зөвлөлдсөний дараа хоёр ажиллагааг нэгтгэхээр шийдвэрлэж болно.

- 5.9. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал нь үндсэн болон нэмэлт зардлаас бүрдэх бөгөөд зардалтай холбоотой харилцааг “Давж заалдах комиссын зардлын журам”-аар зохицуулна.
- 5.10. Давж заалдах комиссын ажиллагааны явцад гарсан дараах нэмэлт зардлыг Бүрэлдэхүүнээс тогтоосон хугацаанд төлнө.
 - 5.10.1. Зөвлөх, шинжээчтэй холбогдон гарах зардал, Бүрэлдэхүүний шийдвэрээр гүйцэтгэсэн ажиллагаа нь тухайн этгээдийн үндсэн ажил үүрэгт хамаарахгүй бол тэдгээрийн ажлын хөлс,
 - 5.10.2. Үзлэг хийхэд гарсан зардал, томилолтын зардал,
 - 5.10.3. Давж заалдах комиссын байнгын байрлах газраас өөр газарт ажиллагаа, хуралдаан явуулсантай холбогдсон зардал,
 - 5.10.4. Шуудангийн зардал, хэлмэрчлэл, орчуулга хийх, гэрчийн зардал, Бүрэлдэхүүний болон нарийн бичгийн даргын томилолтын зардал
 - 5.10.5. Дуудсан гэрчийг хуралдаанд оролцуулахад бэлэн байлгах
 - 5.10.6. Бусад зардал.

Зургаадугаар зүйл. Түр болон Хамгаалах арга хэмжээнүүд

- 6.1. Бүрэлдэхүүнд хэргийн материалыг шилжүүлэхээс өмнө бол Комиссын дарга, эсвэл Бүрэлдэхүүн аль нэг талын хүсэлтээр түр эсвэл хамгаалах арга хэмжээ авах шийдвэр гаргаж болно.
- 6.2. Түр арга хэмжээ авах хүсэлт гаргасан тохиолдолд Комиссын дарга эсвэл Бүрэлдэхүүн нь бусад тал буюу талуудаас тухайн хүсэлтийн нөхцөл байдлыг харгалзан зохих хугацааны дотор байр сууриа илэрхийлэхийг хүсэж болно. Комиссын дарга эсвэл Бүрэлдэхүүн түргэвчилсэн журмаар харьяаллыг тогтоосон шийдвэр гаргаж болно. Комиссын дарга Давж заалдах комиссын харьяалал биш гэсэн шийдвэр гаргасан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгоно.
- 6.3. Нэн яаралтай тохиолдолд, хэргийн материалыг Бүрэлдэхүүнд шилжүүлэхээс өмнө Комиссын дарга, эсвэл үүнээс хойш Бүрэлдэхүүн даргалагч зөвхөн хүсэлт гаргасныг үндэслэн *ex parte* (нөгөө талд мэдэгдэл хүргүүлэлгүй) шийдвэр гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд дараа нь нөгөө талын тайлбарыг авсан байх.
- 6.4. Бүрэлдэхүүн, томилогдоогүй бол Комиссын дарга түр арга хэмжээ авах хүсэлтийг холбогдох допингийн эсрэг дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ. Давж заалдах комиссоос ногдуулсан аливаа түр түдгэлзүүлэлтийг холбогдох Допингийн эсрэг дүрмийн дагуу хэрэгжүүлнэ. Түр арга хэмжээ авах аливаа шийдвэр гаргахаас өмнө, эсвэл хэрэв нөхцөл байдлын улмаас тухайн шийдвэр гарахаас өмнө тайлбар авах боломжгүй байсан бол түр арга хэмжээ авсны дараа бүх нөхцөл байдалд хамгийн боломжит түргэн хугацаанд цаг тухайд нь талуудад бичгээр эсвэл биечлэн тайлбар гаргах боломжийг олгох шаардлагатай.
- 6.5. Асуудлыг үндэслэлд нь тулгуурлаж шийдвэрлэх боломжтой тохиолдолд, мөн хуралдааныг түр арга хэмжээ хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэхээс өмнө явуулах боломжтой тохиолдолд түр арга хэмжээний тухай тусдаа шийдвэр гаргах шаардлагагүй.

Долоодугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлэх

- 7.1. Хэрэг үүсгэсэн тухай мэдэгдэл, өргөдөл болон түүнд хавсаргасан баримт, хэрэг хянан шийдвэрлэх дүрмийг хариуцагчид энэхүү дүрмийн 8 дугаар зүйлд заасны дагуу хүргүүлснээр

- Давж заалдах комиссын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхэлсэнд тооцно.
- 7.2. Талууд энэ дүрмийн 7.1 дэх хэсэгт заасан баримтыг хүргүүлснээс хойш дотоодын маргааны хувьд 7 хоногийн дотор, олон улсын маргааны хувьд 14 хоногийн дотор хариу тайлбарыг ирүүлж мэдэгдэнэ. Хариу тайлбар өгөх хугацааг сунгах талаар үндэслэл бүхий хүсэлт гаргавал нөгөө тал (эсвэл талууд)-тай зөвлөлдсөний үндсэн дээр Бүрэлдэхүүн даргалагч, хэрэв хараахан томилогдоогүй бол Комиссын дарга хариу тайлбар өгөх хугацааг сунгаж болно.
 - 7.3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэд хэдэн өргөдөл гаргагч, хариуцагчид оролцож болох бөгөөд үндсэн болон сөрөг өргөдөл, нэхэмжлэл, тайлбаруудыг тус бүрт нь хүргүүлнэ.
 - 7.4. Хэд хэдэн өргөдөл гаргагч, хариуцагч оролцож байгаа тохиолдолд сүүлчийн этгээдэд мэдэгдэл хүргэгдсэнээр хугацааг тоолно.
 - 7.5. Хэрэв талууд тогтоосон хугацаанд хариу тайлбар ирүүлээгүй бол энэхүү дүрмийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цааш үргэлжлүүлнэ.
 - 7.6. Хариуцагч үндсэн өргөдлийн шаардлагатай холбоотой асуудлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болохоос өмнө сөрөг өргөдөл, нэхэмжлэл гаргах эрхтэй. Сөрөг өргөдөл, нэхэмжлэл нь энэ дүрэмд заасан үндсэн өргөдөл гаргах шаардлага, бүрдүүлбэрийг хангасан байна.
 - 7.7. Давж заалдах комисс болон Бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг аль болох хурдан дуусгах шаардлагатай бөгөөд тэмцээн, наадамтай холбогдуулан хянан шийдвэрлэх ажиллагааг түргэвчилсэн журмаар хийж болно.

Наймдугаар зүйл. Хугацаа тоолох, бичиг баримт болох захидал харилцаа

- 8.1. Талууд маргаанд холбогдох бүхий л баримт бичиг, мэдэгдлийг Ажлын албанд эсхүл Бүрэлдэхүүн томилогдсон бол Бүрэлдэхүүнд хүргүүлнэ.
- 8.2. Талууд баримт бичгийг хүрэлцэн ирж авах бөгөөд боломжгүй бол талуудын мэдэгдсэн эсхүл хамгийн сүүлд мэдэгдэж байсан, түүний үйл ажиллагаа явуулдаг, эсхүл байнга оршин байгаа, мөн үйл ажиллагаагаа байнга явуулдаг газар, шуудангийн хаягаар, харин эдгээрийг тогтоох боломжгүй бол гэрээний эсхүл эрх бүхий байгууллагаас ирүүлсэн лавлагаанд дурдсан хаягаар баталгаат шуудангаар хүргүүлнэ. Ийнхүү хүргүүлснээ баримтаар баталгаажуулсан бол хүлээн авсанд тооцно.
- 8.3. Баримт бичиг, мэдэгдлийг факс, телеграмм, цахим шуудан болон бусад техник технологийн хэрэгслийг ашигласан, шаардлагатай онцгой тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслээр зар хүргэсэн, хүргэх оролдлого хийсэн /факс, мессеж, и-мэйл хаягаар г.м./ тэмдэглэл үйлдэх зэрэг боломжит бүх арга, хэрэгслийг ашигласан байвал хүлээн авсантай адилтган тооцно.
- 8.4. Бичиг баримт, мэдэгдлийг энэ зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу хүргэсэн өдрийг зохих хугацаанд хүлээн авсан өдөрт тооцно.
- 8.5. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдэгдлийг хүлээн авагчид цахим шуудангаар эсхүл бусад цахим харилцаа холбоогоор илгээснийг хүлээн авсан өдөрт тооцно.
- 8.6. Мэдэгдэл, баримт бичгийг хүлээн авсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өдрийг хуанлийн тооллоор, цагийг тухайн ажиллагаа явагдах улс, орны орон нутгийн цагаар тодорхойлно.
- 8.7. Хэрэв тогтоосон хугацааны сүүлийн өдөр нь амралтын, нийтээр амрах баяр ёслолын өдөр эсхүл хүлээн авагчийн оршин байгаа улс орон, бүс нутгийн нийтийг хамарсан баяр, амралтын өдөр бол энэ хугацаа нь дараагийн ажлын эхний өдрөөр тооцогдоно.
- 8.8. Хугацааг хуанлийн өдрөөр тоолох бөгөөд мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс тоолно. Хугацааг

тооцохдоо албан ёсны нийтээр амрах баярын өдрүүд болон ажлын бус өдрүүдийг багтаасан.

Есдүгээр зүйл. **Комиссын бүрэлдэхүүнийг томилох**

- 9.1. Давж заалдах комиссын нэрсийн жагсаалтаас Комиссын дарга нь тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах Бүрэлдэхүүнд хууль, спорт, анагаах ухааны салбараас тус бүр нэг буюу нийт 3 (даргалагч, гишүүд) гишүүнтэй томилно.
- 9.2. Бүрэлдэхүүн томилогдмогц Ажлын алба эсхүл Комиссын дарга хэргийн материалыг Бүрэлдэхүүнд шилжүүлнэ.
- 9.3. Томилогдсон Бүрэлдэхүүн нь талуудад үйлчлэх, зөвлөх, шинжээчээр ажиллах, зөвлөгөө, туслалцаа өгөхийг хориглох бөгөөд талуудаас хараат бус, бие даасан байна.
- 9.4. Томилогдсон Бүрэлдэхүүн нь хэргийг шийдвэрлэхдээ бие даасан, хараат бус, бусдын нөлөөнд автахгүйгээр шударгаар хандахаа илэрхийлсэн Хараат бус байдлын мэдүүлэг, Нууц хамгаалах мэдэгдэлд гарын үсэг зурна.
- 9.5. Допингийн эсрэг үндэсний дүрмийн 13 дугаар зүйлийн 13.9.5-д заасны дагуу Комиссын даргын томилсон гишүүн ямар нэг шалтгаанаар тухайн хэрэгт холбоотой байвал Комиссын дарга нь тухайн гишүүнийг солих эсхүл Бүрэлдэхүүнийг өөрчилнө.
- 9.6. Бүрэлдэхүүнд томилогдсон гишүүд нь өмнө болон одоо Үндэсний допингийн эсрэг байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүд, ажилтнууд, комиссын гишүүд, зөвлөхүүд, мөрдөн шалгалт, хэрэг хянан хэлэлцэх ажиллагаанд оролцсон ажилтан байж болохгүй бөгөөд ЭЗЧ аливаа ажиллагаа, үр дүнгийн удирдлагын шийдвэр гаргахад оролцоогүй байх шаардлагатай.
- 9.7. Комиссын гишүүд болон Бүрэлдэхүүний ажлын ачаалал, бие даасан, хараат бус байдалд эргэлзээ төрсөн, Бүрэлдэхүүнд орж ажиллахаас татгалзсан, Бүрэлдэхүүнээс татгалзан гаргасан, Комиссын гишүүний эрх, үүрэг дуусгавар болсон бол Комиссын гишүүнээр ажиллах шаардлага хангасан Спортын арбитрчаас сонгож Бүрэлдэхүүнд томилох шийдвэрийг Комиссын дарга гаргаж болно.

Аравдугаар зүйл. **Хараат бус, бие даасан байдал**

- 10.1. Давж заалдах комисс, Бүрэлдэхүүн нь хэрэг хянан шийдвэрлэх, шийдвэр гаргах бүхий л үйл ажиллагаа нь Үндэсний допингийн эсрэг байгууллага болон аливаа гуравдагч этгээдээс ангид байна. Давж заалдах комисс нь Дэлхийн допингийн эсрэг дүрэмд заасны дагуу үйл ажиллагааны болон байгууллагын хараат бус байдлын тодорхойлолтод заасан шаардлагыг хангана.
- 10.2. Бүрэлдэхүүн бүр талуудаас хараат бус, бие даасан байх үүрэгтэй бөгөөд аливаа талын хувьд өөрийн хараат бус, бие даасан байдалд нөлөөлж болох одоогийн болон хожим нь үүсэж болох аливаа нөхцөл байдлын талаар нэн даруй Комиссын даргад мэдэгдэх үүрэгтэй.
- 10.3. Бүрэлдэхүүн бүр шаардлагатай тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэвчилсэн байдлаар дуусгахад бэлэн байх үүрэгтэй.
- 10.4. Давж заалдах комиссын нэрсийн жагсаалтад орсон гишүүн Спортын арбитрын явуулж буй аливаа арбитрын ажиллагаанд арбитрчийн үүрэг гүйцэтгэж болохгүй.
- 10.5. Бүрэлдэхүүнд томилогдох хүсэлт авсан этгээд тухайн маргаанд ажиллахаа хүлээн зөвшөөрч Хараат бус байдлын мэдүүлэг, Нууц хамгаалах мэдэгдэлд гарийн үсэг зурахаас өмнө талуудын талаарх мэдээлэл, өргөдөлтэй танилцан өөрийн хараат бус, бие даасан байдалд эргэлзээ

төрүүлэх нөхцөл байдал байгаа болон ажиллах бусад боломжгүй талаар Комиссын даргад мэдэгдэх үүрэгтэй. Үүнд:

- 10.5.1. Талуудтай аливаа маргаантай асуудлаар шүүх, арбитраар хэрэг хянан шийдвэрлэхэд шүүгч, арбитраар, хэргийн оролцогч, зохигч, гуравдагч этгээд, өмгөөлөгч, гэрч, зөвлөх, шинжээч, хэлмэрч, орчуулагчаар оролцож байсан
 - 10.5.2. Талууд, өмгөөлөгч, төлөөлөгч нь Бүрэлдэхүүнд байгаа гишүүнтэй төрөл садан, хувийн харилцаатай, сүүлийн гурван жилийн байдлаар захирах, захирагдах харилцаанд байсан
 - 10.5.3. Талуудад мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж байсан, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчидтэй хамтран ажиллаж байсан, нэгдмэл сонирхолтой
 - 10.5.4. Бусад нөхцөл байдлын улмаас хэргийг шударгаар шийдвэрлэж чадах талаар үндэслэл бүхий эргэлзээтэй байдал байгаа бол
- 10.6. Давж заалдах комиссын гишүүн нь Бүрэлдэхүүнд томилогдсоноо хүлээн зөвшөөрч Хараат бус байдлын мэдүүлэгт, Нууц хамгаалах мэдэгдэлд гарын үсэг зурсан үеэс хойш Бүрэлдэхүүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно.

Арваннэг дүгээр зүйл.

Татгалзан гаргах үндэслэл, журам

- 11.1. Бүрэлдэхүүн эсхүл Бүрэлдэхүүний гишүүнийг зөвхөн энэхүү дүрмийн 10.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хараат бус, бие даасан байдалд эргэлзээ төрүүлэхүйц үндэслэл бүхий нөхцөл байдал байгаа үндэслэлээр татгалзан гаргах хүсэлт гаргана.
- 11.2. Талууд Бүрэлдэхүүний хараат бус байдлын мэдүүлгийг хүлээн авснаас хойш 7 хоног (олон улсын маргаанд 14 хоног)-ийн дотор илэрхий болсон үндэслэлээр түүнийг татгалзан гаргах тухай үндэслэл бүхий хүсэлтээ баримтаар баталгаажуулан гаргах бөгөөд хүсэлтээ Ажлын албанд эсхүл Комиссын даргад хүргүүлнэ.
- 11.3. Татгалзан гаргах хүсэлтийг Комиссын дарга эцэслэн шийдвэрлэнэ.
- 11.4. Татгалзан гаргасан Бүрэлдэхүүн эсхүл Бүрэлдэхүүний гишүүнийг өөрийн оронд ажиллах Бүрэлдэхүүн эсхүл Бүрэлдэхүүний гишүүн томилогдох хүртэл үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэж болно.
- 11.5. Комиссын дарга татгалзан гаргасан шийдвэрийнхээ товч үндэслэлийг тайлбарлах үүрэгтэй бөгөөд мөн олон нийтэд хэвлэн нийтлэхээр шийдвэрлэж болно.

Арванхоёр дугаар зүйл. **Нөхөн томилох, чөлөөлөх**

- 12.1. Комиссын гишүүнийг татгалзан гаргасан буюу үүргээ удаан хугацаагаар гүйцэтгэх боломжгүй болсон, эсхүл өөрөө гишүүнээр ажиллахаас татгалзсан, гишүүнээс чөлөөлөгдсөн бол түүний эрх, үүрэг дуусгавар болж гишүүнийг нөхөн томилно.
- 12.2. Бүрэлдэхүүний гишүүн энэхүү дүрэмд заасны дагуу зохих хугацаанд үүргээ биелүүлэхээс татгалзсан эсвэл үүргээ биелүүлэх боломжгүй болсон, ёс зүйн зөрчил гаргасан, Комиссын нэр хүнд, албаны нэр төрд харшилсан үйлдэл эс үйлдэл гаргасан бол Бүрэлдэхүүний гишүүний үүргээс чөлөөлнө. Энэ тухай талуудад болон өөрт нь мэдэгдэж тайлбар гаргах хугацааг олгоно.
- 12.3. Энэхүү зүйлийн 12.1, 12.2 дахь хэсэгт заасны дагуу шинэ гишүүнийг тухайн гишүүнийг томилсон журмын дагуу нөхөн томилсон Комиссын даргын шийдвэр эцсийнх байна.
- 12.4. Аливаа тал Комиссын гишүүнийг үүргээс нь чөлөөлөх хүсэлт гаргах эрхгүй байна.

12.5. Бүрэлдэхүүн нөхөн томилогдсон бол өмнөх Бүрэлдэхүүний ажиллагаанаас хойш үргэлжлүүлэн явуулна.

Арвангурав дугаар зүйл. **Нотлох баримт, түүнийг гаргах, цуглуулах**

- 13.1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотлох баримт нь талууд, тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээдийн бичгэн болон аман тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл болон электрон хэлбэр дэх баримтууд, зөвлөхийн болон шинжээчийн дүгнэлт, эд мөрийн баримт, үзлэгийн тэмдэглэл зэргээс бүрдэнэ.
- 13.2. Бүрэлдэхүүн маргааны бодит байдлыг тогтоохдоо гэрч дуудах, зөвлөх болон шинжээч томилох, үзлэг хийх болон баримт бичиг нэмж гаргуулах, энэхүү дүрэм болон Дэлхийн допингийн эсрэг дүрмээр зөвшөөрсөн бусад ажиллагаа /туршилт хийх, даалгавар бичих г.м/-г хийнэ.
- 13.3. Шаардлагатай бол талуудын хүсэлт эсхүл Бүрэлдэхүүн зөвлөхийн болон шинжээчийн дүгнэлт гаргуулахаар нарийн мэргэжлийн, хөндлөнгийн зөвлөх, шинжээч томилно. Зөвлөх, шинжээч нь хувь хүн, байгууллага байна.
- 13.4. Бүрэлдэхүүн Допингийн эсрэг үндэсний дүрмийн 3.3.3, 3.3.5-д заасны дагуу шинжээч томилно.
- 13.5. Хуралдаан болохоос өмнө Дэлхийн допингийн эсрэг агентлагийн хүсэлтээр нотлох баримтыг үнэлэхэд туслах мэргэжлийн шинжээчийг томилж болно.
- 13.6. Зөвлөх, шинжээч нь зарчмын хувьд тухайн томилгоог хүлээн авахын өмнө Бүрэлдэхүүнд өөрийн мэргэшил болон бие даасан, талуудаас Хараат бус байдлын талаарх мэдэгдлийг ирүүлнэ.
- 13.7. Зөвлөх, шинжээч нь шаардлагатай гэж үзвэл тухайн хэргийн материалтай танилцах, нэмэлт материал гаргаж өгөхийг Бүрэлдэхүүн болон талуудаас шаардах, үзлэг хийх эрхтэй.
- 13.8. Давж заалдах комиссын шийдвэр гаргахад ашиглаж буй зөвлөхийн болон шинжээчийн дүгнэлт, нотолгооны шинжтэй бусад баримт бичгийг Бүрэлдэхүүн талуудад мөн нэг адил хүргүүлнэ.
- 13.9. Зөвлөхийн болон Шинжээч дүгнэлтийг шударгаар гаргах нь эргэлзээтэй гэж үзвэл талууд түүнээс татгалзаж болно. Ийнхүү татгалзан гарах асуудлыг Бүрэлдэхүүн эцэслэн шийдвэрлэнэ.
- 13.10. Нэгээс дээш зөвлөх, шинжээч томилогдсон бол аль нэг зөвлөх, шинжээч нь бусад зөвлөх, шинжээчийн дүгнэлттэй санал нийлэхгүй байвал дүгнэлт, тайлбараа тусад нь гаргаж болно.
- 13.11. Бүрэлдэхүүн хэргийг хянан шийдвэрлэх, зөвлөхийн болон шинжээч дүгнэлт гаргахдаа зарим байдлыг тодруулахын тулд байр, хөрөнгө, цахим сан, баримт бичигт гэх мэт зүйлд үзлэг хийж болно.
- 13.12. Үзлэгийг хийхдээ хэргийн оролцогчид мэдэгдэж, тэмдэглэл үйлдэнэ. Хэргийн оролцогчид ирээгүй явдал нь үзлэг хийхэд саад болохгүй.
- 13.13. Талууд Бүрэлдэхүүний шаардсан бичиг баримт, бодит нотлох баримт болон бусад нотлох баримтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, тогтсон хугацаанд гаргаж өгөөгүй бол Бүрэлдэхүүн хэрэгт цугларсан нотлох баримтын хүрээнд шийдвэр гаргаж болно.
- 13.14. Бүрэлдэхүүн шаардлагатай бол талуудаас нэмэлт нотлох баримт шаардах бөгөөд эдгээрийг ирүүлэх хугацааг тогтооно.
- 13.15. Нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас харьцуулах, жиших аргачлалаар үнэлэх нь Бүрэлдэхүүний бүрэн эрхэд хамаарна.

- 13.16.Талууд, тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээд нь өөрийн шаардлага, татгалзлын үндэслэл болж байгаа нөхцөл байдлыг өөрөө нотлох үүрэгтэй.
- 13.17.Талууд, тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээд нь хуурамч нотлох баримт гаргах буюу хууль бус аргаар цуглуулахыг хориглоно. Ийм арга хэлбэрээр гаргасан нотлох баримт нь нотлох чанараа алдах бөгөөд Давж заалдах комиссын шийдвэрийн үндэслэл болохгүй. Хуурамч баримтын талаар товч үндэслэлийг тайлбарлан олон нийтэд хэвлэн нийтлэхээр шийдвэрлэж болно.
- 13.18.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуралдааны үед шинэ нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай гэж үзвэл Бүрэлдэхүүн хуралдааныг хойшлуулж болно.
- 13.19.Бүрэлдэхүүн нотлох баримт бүрдүүлэхэд шүүх болон бусад байгууллага туслалцаа үзүүлнэ.

Арвандөрөв дүгээр зүйл. Талуудын эрх, үүрэг ба гуравдагч этгээд

- 14.1. Талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тайлбар, хүсэлт гаргах, үг хэлэх, нотлох баримт гаргах, мэтгэлцэх боломжоор хангагдана. Харин энэхүү эрхээ эдлээгүйгээр ажиллагаанд оролцоод явсан бол уг эрхээ эдэлсэнтэй адилтган тооцно.
- 14.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талууд нь дараах эрхийг эдэлнэ.
- 14.2.1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед хэргийн материалтай танилцах, хуулбарлан авах, тэмдэглэл үйлдэх, хуралдааны үед Бүрэлдэхүүн даргалагчийн зөвшөөрлөөр бусад оролцогчдод асуулт тавих, хариулт авах;
- 14.2.2. Зөвлөх, шинжээч томилуулах, үзлэг явуулах, гэрч асуулгах, хэлмэрч, орчуулагч оролцуулах тухай хүсэлт гаргах;
- 14.2.3. Бүрэлдэхүүн, Бүрэлдэхүүний гишүүн, зөвлөх, шинжээч, орчуулагч, гэрч, хэлмэрч бусад этгээдийг татгалзах;
- 14.2.4. Өргөдөл гаргагч нь өргөдөл гаргасан үндэслэл буюу өргөдлөө өөрчлөх, өргөдлийн шаардлагын хэмжээг ихэсгэх буюу багасгах, эсхүл өргөдлөөсөө бүрмөсөн татгалзах, эвлэрэн хэлэлцэх;
- 14.2.5. Хариуцагч нь өргөдөл, өргөдлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, татгалзах, сөрөг өргөдөл, нэхэмжлэл гаргах, эвлэрэн хэлэлцэх;
- 14.2.6. Энэхүү дүрэмд заасан үндэслэл болон хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаан хойшлуулах хүсэлт гаргах;
- 14.3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талууд нь дараах үүргийг хүлээнэ.
- 14.3.1. Өргөдөл болон татгалзлын үндэслэл болох нөхцөл байдлыг өөрөө нотлох.
- 14.3.2. Бүрэлдэхүүн болон нарийн бичгийн даргаас тавьсан шаардлагыг биелүүлэх
- 14.3.3. Бүрэлдэхүүний гаргасан шийдвэрийг биелүүлэх
- 14.3.4. Хуралдаанд хүрэлцэн ирэх
- 14.3.5. Нууц хамгаалах мэдэгдлийг биелүүлэх.
- 14.4. Талууд иргэн бол төлөөлөгч оролцуулахдаа эдлэх эрх, үүргийг нь тодорхойлсон, нотариатаар баталгаажуулсан итгэмжлэлийг ирүүлнэ. Харин талууд хуулийн этгээд бол албан бичгээр итгэмжлэл олгож, гэрчилгээ, дүрмийг хавсаргана.
- 14.5. Итгэмжлэл Монгол улсын Иргэний хуулийн 64 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангах бөгөөд нэмэлтээр цахим шуудангийн хаяг, харилцах утасны дугаарыг тусгасан байна.
- 14.6. Өмгөөлөгч оролцох бол хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг ирүүлнэ. Талууд болон тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч ажиллагааны тухай мэдэгдлийн дагуу оролцоогүй, хуралдаанд ирээгүй, эсхүл хуралдааны явцад хурлыг орхин гарсан нөхцөлд, нөгөө талын

саналыг харгалзан хуралдааныг хойшлуулах, эсхүл хуралдааныг ердийн журмаар үргэлжлүүлнэ.

- 14.7. Талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдийг татан оролцуулах талаар хүсэлт гаргах эрхтэй бөгөөд хүсэлтээ нотолсон холбогдох баримт бичгийг хавсаргана. Бүрэлдэхүүн хүсэлтийг үндэслэлтэй гэж шийдсэн бол гуравдагч этгээдээр татсан шийдвэр, хүсэлт түүний хавсралтуудыг танилцуулах бөгөөд тайлбар гаргах хугацааг тогтоож өгнө.
- 14.8. Хэрэв гуравдагч этгээд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзвал мэдэгдэл хүлээн авснаас хойш 7 хоног (олон улсын маргаанд 14 хоног)-ийн дотор шалтгаанаа нотлох баримтын хамт бичгээр ирүүлнэ.
- 14.9. Гуравдагч этгээд нь Допингийн эсрэг үндэсний дүрмээр үүрэг хүлээсэн эсхүл хэлэлцээрээр үүрэг хүлээсэн эсхүл хэргийн оролцогчид тохиролцон бичгээр хэлэлцээр хийсэн бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах эрхгүй.
- 14.10. Аливаа этгээд өөрийн хүсэлтээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдээр оролцох хүсэлтийг гаргаж болох бөгөөд уг хүсэлтийг талуудад танилцуулсны дараа оролцуулах эсэхийг Бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

Арвантав дугаар зүйл. Тэмдэглэл

- 15.1. Хэрэг хянан шийдвэрлэх хуралдаан болон хуралдаанаас гадуур явагдсан бусад ажиллагааны талаар бичгийн эсхүл цахим буюу аудио, видео тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлийг хуралдааны нарийн бичгийн дарга хөтөлнө. Тэмдэглэлд хуралдаан даргалагч болон хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурж албажуулна.
- 15.2. Тэмдэглэлд хуралдаан болон ажиллагааг хэн, хэзээ, хаана явуулсан, түүний эхэлсэн, дууссан цаг, түүнд оролцогчдын овог нэр, хаяг, түүнчлэн үйл ажиллагааны дэс дараалал, явц, илэрсэн нөхцөл байдлыг бичнэ.
- 15.3. Хуралдааны явц болон бусад ажиллагааг зөвхөн нарийн бичгийн дарга, түр ажилтан, шаардлагатай бол мэргэжлийн байгууллага, ажилтнаар техник хэрэгсэл ашиглан дуу, дүрс, фото, бичлэг хийх, хуулбарлан буулгаж болно.
- 15.4. Хэргийн оролцогчид хуралдааны тэмдэглэлтэй танилцаж болно. Энэ тохиолдолд танилцсан этгээдээр гарын үсэг зуруулсан байна.

Арванзургаа дугаар зүйл. Талууд үүргээ биелүүлэхгүй байх, үүсэх үр дагавар

- 16.1. Талууд ажиллагааны талаар болон хуралдааны товыг хүлээн авсан боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй, эсхүл тогтоосон хугацаанд нотлох баримтаа гаргаж өгөөгүй бол Бүрэлдэхүүн ажиллагааг үргэлжлүүлж, цугларсан нотлох баримтад үндэслэн шийдвэр гаргана.
- 16.2. Хэрэв Хариуцагч хариу тайлбараа гаргаагүй тохиолдолд Бүрэлдэхүүн үүнээс үл хамаарч ажиллагааг үргэлжлүүлж, үндсэн шийдвэр гаргана.
- 16.3. Хэрэв аливаа тал эсвэл түүний гэрчийг зохих ёсоор дуудсан боловч хуралдаанд оролцоогүй тохиолдолд Бүрэлдэхүүн үүнээс үл хамаарч хуралдааныг хийж, үндсэн шийдвэр гаргана.

Арвандолоо дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх хуралдаан

- 17.1. Хэрэг хянан шийдвэрлэх хуралдааныг талуудыг оролцуулан биечлэн эсхүл видео-хуралдаан, эсхүл хэргийн оролцогч, гэрч, зөвлөх, шинжээч нарын саналыг видео хуралдааны хэлбэрээр явуулж болно. Хэргийн оролцогчид зөвшөөрсөн бол гэрч болон зөвлөх, шинжээчээс

- урьдчилан мэдүүлэг авч хэрэг хянан шийдвэрлэх хуралдаанд биечлэн оролцохоос чөлөөлж болно.
- 17.2. Бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хугацаанд нь түргэн шуурхай явуулахын тулд талуудын саналыг харгалзан түргэвчилсэн журам болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны завсрын хуваарийг тогтоож, харилцан тохиролцсон хугацааг сунгах эсхүл богиносгож болно.
 - 17.3. Бүрэлдэхүүн маргааныг холбогдох допингийн эсрэг дүрмийн дагуу эсвэл Монгол Улсын Допингийн эсрэг үндэсний дүрмийн дагуу шийдвэрлэнэ.
 - 17.4. Хэрэг хянан шийдвэрлэх хуралдааныг талуудыг оролцуулан хийнэ. Хэрэв талууд хэрэг хянан шийдвэрлэх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биечлэн оролцоогүй эсхүл оролцохгүй тухай хүсэлт гаргасан бол Бүрэлдэхүүнд маргааныг хэрэгт авагдсан нотлох баримтыг үндэслэн зөвлөлдөх журмаар шийдвэрлэнэ.
 - 17.5. Талууд хэрэг хянан шийдвэрлэх хуралдаанд оролцохоор тохиролцсон, эсхүл аль нэг тал ийнхүү хүсэлт гаргасан бол Бүрэлдэхүүн талуудыг оролцуулан хэрэг хянан шийдвэрлэх хуралдааныг мэтгэлцэх зарчмаар явуулж хэргийг шийдвэрлэнэ.
 - 17.6. Бүрэлдэхүүн даргалагч аль болох боломжит түргэн хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх хуралдааны талаар шийдвэр гаргаж, хуралдаан болох өдрийг тогтооно.
 - 17.7. Хэрэг хянан шийдвэрлэх хуралдаан болох газар, огноог талуудад урьдчилан /харилцаа холбоо, цахим шуудан болон бүх боломжит хувилбараар/ мэдэгдэнэ.
 - 17.8. Бүрэлдэхүүн даргалагч хэрэг хянан шийдвэрлэх хуралдааныг удирдан явуулна. Тамирчин эсхүл бусад этгээд хэрэг хянан шийдвэрлэх хуралдааныг олон нийтийн өмнө нээлттэй явуулах хүсэлтийг гаргах эрхтэй.
 - 17.9. Энэхүү дүрмийн 17.8-д заасан олон нийтийн өмнө нээлттэй явуулах хүсэлт нь ёс суртахуун, нийтийн хэв журам, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, насанд хүрээгүй хүмүүсийн ашиг сонирхол, талуудын хувийн нууцыг хамгаалах шаардлагатай тохиолдолд, нийтэд мэдээлэх нь тэдгээрийн эрх ашигт хохирол учруулах бол эсвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь зөвхөн хуулийн асуудалтай холбоотой тохиолдолд Бүрэлдэхүүн уг хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж болно.
 - 17.10. Олон улсын холбоо, Үндэсний спортын холбоо, Үндэсний олимпын хороо, Үндэсний паралимпын хороо нь хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч биш бол Дэлхийн допингийн эсрэг агентлаг ажиглагчаар оролцоно.
 - 17.11. Бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэхдээ хэргийн талаар авагдсан нотлох баримтыг бүх талаас нь шинжлэн судалж, хэргийн оролцогчдын шаардлага, тайлбарыг сонсож, талуудыг тайлбар хийх адил боломжоор хангана.
 - 17.12. Бүрэлдэхүүн хэргийн оролцогчдын тайлбарыг сонссоны дараа нэмэлт материал цуглуулах шаардлагатай гэж үзвэл ажиллагааны аль ч үед гэрчээс мэдүүлэг авч, зөвлөхийн болон шинжээчийн дүгнэлтийг сонсож мөн хэргийн үнэн зөвийг тогтооход шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
 - 17.13. Хэрэг хянан шийдвэрлэх хуралдаан завсарласнаар Бүрэлдэхүүн тусгайлан зөвлөлдөх бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл өөрийн санаачилгаар шийдвэр гаргахаас өмнө хуралдааныг дахин үргэлжлүүлж болно.
 - 17.14. Бүрэлдэхүүн зөвлөлдөөнийг хаалттай хийж шийдвэрээ гаргах бөгөөд шийдвэрийн агуулгыг товч танилцуулж хуралдааныг хаана.
 - 17.15. Хэрэг хянан шийдвэрлэх хуралдаан хааснаас хойш Бүрэлдэхүүнд нэмэлт бичгэн мэдэгдэл

гаргах эрхгүй байна.

Арваннайм дугаар зүйл. Давж заалдах комиссын шийдвэр

- 18.1. Давж заалдах комиссын шийдвэрийг Бүрэлдэхүүн олонхийн саналаар гаргана.
- 18.2. Бүрэлдэхүүн томилогдоогүй бол Комиссын дарга хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аливаа шийдвэрт огноог тавьж гарын үсэг зурна. Бүрэлдэхүүн даргалагч дангаараа гарын үсэг зурж болно эсвэл хоёр гишүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 18.3. Бүрэлдэхүүн болон Комиссын даргын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан гаргасан шийдвэр эцсийнх байна.
- 18.4. Давж заалдах комиссын шийдвэр нь эцсийнх байх бөгөөд заавал биелэгдэнэ.
- 18.5. Давж заалдах комиссын шийдвэрийн агуулгыг танилцуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор бичгээр гаргаж, ёсчилсон буюу албажуулсан байна.
- 18.6. Давж заалдах комиссын шийдвэрийн дүгнэлтийн болон тогтоох (шийдвэрийг гаргах болсон үндэслэл, эрх хасах шийтгэл оноосон бол түүний хугацаа болон бусад боломжит шийтгэлийг оноогоогүй үндэслэл зэргийг багтаана) хэсгийг Бүрэлдэхүүн даргалагч үйлдэж, Ажлын алба бусад хэсгийг нэгтгэн, Бүрэлдэхүүний гишүүдийн саналыг авч, алдааг хянаж, тэмдэг дарах, дугаар өгөх ажиллагааг гүйцэтгэнэ.
- 18.7. Давж заалдах комиссын шийдвэр гаргасан огноог хэрэг хянан шийдвэрлэх хуралдаан явуулсан өдөр байна.
- 18.8. Давж заалдах комиссын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан нэмэлт зардлыг талууд бүрэн төлөх хүртэл шийдвэрийг талуудад хүргүүлэх ажиллагааг хойшлуулж болно.

Арванес дүгээр зүйл. Давж заалдах комиссын шийдвэрт засвар, өөрчлөлт хийх

- 19.1. Хэрэв тухайн шийдвэрийн заавал биелүүлэх хүчинтэй хэсэг тодорхой бус, бүрэн бус, ойлгомжгүй, хэрэв бүрэлдэхүүн хэсгүүд нь хоорондоо зөрчилдсөн эсвэл үндэслэлтэй нийцэхгүй, эсвэл үндсэн шийдвэрт үг үсгийн алдаа эсвэл тооны буруу тооцоолол байгаа тохиолдолд үндсэн шийдвэрийн талаарх шийдвэрлэгдээгүй байгаа давж заалдах гомдлын үр дагаврыг харгалзан тал нь тухайн шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор Ажлын албанд хандаж үндсэн шийдвэрийн засвар оруулах, тайлбарлах хүсэлт гаргана. Тайлбар авах хүсэлт нь давж заалдах гомдол гаргах хугацаанд нөлөөлөхгүй.
- 19.2. Тайлбар авах хүсэлт гаргасан тохиолдолд холбогдох Комиссын дарга тайлбар өгөх үндэслэл буй эсэхийг хянаж үзнэ. Хэрэв үндэслэл байна гэж үзвэл тухайн үндсэн шийдвэрийг гаргасан Бүрэлдэхүүнд тайлбар авах хүсэлт гаргана. Тайлбар хүссэн үед ажиллах боломжгүй байгаа Бүрэлдэхүүний гишүүнийг энэхүү дүрмийн 12 дугаар зүйлийн дагуу солино. Бүрэлдэхүүн тайлбар авах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш нэг сарын дотор тухайн хүсэлтийн талаар шийдвэр гаргана.
- 19.3. Комиссын дарга шийдвэрт засвар оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах үндэслэлгүй гэж үзвэл энэ тухайгаа талуудад бичгээр мэдэгдэнэ.

Хорьдугаар зүйл. Давж заалдах комиссын шийдвэрийг биелүүлэх

- 20.1. Давж заалдах комиссын шийдвэрийг Дэлхийн допингийн эсрэг дүрмийн дагуу хэрэглэж, хүлээн зөвшөөрнө.
- 20.2. Давж заалдах комиссын шийдвэр нь тус улсын нутаг дэвсгэрт, түүнчлэн гадаад улсад нэгэн адил хүчин төгөлдөр гүйцэтгэгдэнэ.

- 20.3. Давж заалдах комиссын шийдвэрийг талууд, Үндэсний допингийн эсрэг байгууллага, Дэлхийн допингийн эсрэг дүрмийг зөвшөөрч гарын үсэг зурсан допингийн эсрэг байгууллагууд болон бусад холбогдох аливаа этгээд шийдвэрийг хүлээн авч, шууд дагаж мөрдөнө.
- 20.4. Давж заалдах комиссын шийдвэрийг эсхүл тухайн шийдвэрийн үндэслэлийг Дэлхийн допингийн эсрэг агентлаг нь ажиллагааны тал биш байх тохиолдолд Дэлхийн допингийн эсрэг агентлагт хүргүүлнэ.
- 20.5. Давж заалдах комиссын шийдвэрийн эх хувь, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хураангуй тайлбар эсхүл үр дүнг тодорхойлсон хэвлэлийн мэдээг Давж заалдах комисс олон нийтэд мэдээлнэ.
- 20.6. Талууд эсхүл Дэлхийн допингийн эсрэг агентлаг, Олон улсын олимпын хороо, Олон улсын паралимпын хороо болон холбогдох Олон улсын холбоод тус тус Давж заалдах комиссын үндсэн шийдвэрийн талаар зөвхөн Олон улсын спортын арбитрын шүүхэд давж заалдах эрхтэй.
- 20.7. Олон улсын спортын арбитрын шүүхэд өргөдөл гаргах эцсийн хугацаа нь үр дүнгийн удирдлагын ажиллагаа явуулж буй Үндэсний допингийн эсрэг байгууллагын дүрэмд зааснаар байна. Дэлхийн допингийн эсрэг агентлагын давж заалдах хугацаа нь Дэлхийн допингийн эсрэг дүрмийн 13.2.3.5-д заасны дагуу байна.

Хориннэг дүгээр зүйл. Бусад

- 21.1. Энэхүү дүрэм нь 2023 оны 12-р сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.
- 21.2. Давж заалдах комиссын дүрмийг нэмэлт байдлаар хэрэглэж болно.
- 21.3. Спортын арбитрын арбитрчид, Давж заалдах комиссын дарга, гишүүд, Ажлын албаны ажилтнууд аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эсвэл Давж заалдах комиссын үндсэн шийдвэртэй холбоотой аливаа үйлдэл, эс үйлдэхүйн төлөө аливаа этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй.
- 21.4. Монгол, Англи хэл дээрх бичвэрүүд нь жинхэнэ эх болно. Аливаа зөрүү гарсан тохиолдолд Дэлхийн допингийн эсрэг агентлагаар хянан баталгаажуулж, зөвшөөрөгдсөн Англи хэл дээрх бичвэрийг баримтална.